



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Ж.Чойхандыг ажилд томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 03/5456 тоот албан бичгээр ирүүлсэн санал болон Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/12351 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Жанчивламдангийн Чойхандыг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ж.Чойхандтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ